



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 30 өдөр

Дугаар А/41

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 4.1, Засаг даргын зөвлөлийн 2024 оны 03 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймгаас Улсын аварга малчин, Алтан төлийн эзэн болсон малчдад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээний зардлыг хавсралтаар баталсугай.
2. Улсын аварга, Алтан төлийн эзэн болсон малчдад хүндэтгэл үзүүлэх зардалд шаардлагатай 2,800,000 (Хоёр сая найман зуун мянган) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т зөвшөөрсүгэй.
3. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М. Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

6712010120

Захирамж2024



Аймгийн Засаг даргын 2024 оны  
01 дүгээр сарын 30-ны өдрийн  
А.Ч. тоот захирамжийн хавсралт

УЛСЫН АВАРГА МАЛЧИН, АЛТАН ТӨЛИЙН ЭЗЭН МАЛЧДАД  
ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЭХ ЗАРДЛЫН ЗАДАРГАА

№	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	Өргөмжлөл	20	75000	1500,000
2	Гарын бэлэг	20	65000	1300,000
	Дүн			2,800,000

-----oOo-----